Авлигатай тэмцэх газар

# Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг

*Хяналт шалгалт, дүн шинжилгээний  хэлтэс*

# Мэдүүлэг, мэдэгдэл тайлбар

ХАСУМ

ХАСХОМ

МЭДЭГДЭЛ, ТАЙЛБАР

СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИЙН ХОМ

## Хэн хянуулах вэ?

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд

Албан тушаалын тодорхойлолт, эрхлэх асуудлын чиг үүрэгт өөрчлөлт орсоны улмаас шилжин, сэлгэн, түр орлон гүйцэтгэгч, туршилтын хугацаагаар томилогдож байгаа

## Бүрдүүлэх материал

meduuleg.iaac.mn цахим хуудсанд хандан ХАСУМ гаргах, түүнийг ЭБАТ илгээх

Албан бичгийг албан тушаалын тодорхойлолтын хамт АТГ-т хүргүүлэх

## Хэрхэн хянах вэ?

Ажлын 10 өдөрт

Ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэх талаар томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэнэ.

# Эрх зүйн орчин

**Авлигын эсрэг хууль**

***4 дүгээр зүйл.*** Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд

**Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль**

**23.5** “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ”

**29.2.2** “**...** энэ хуулийн 8.1, 8.2, 8.3, 9.1, 19.1, 21.3, 21.4, 23.5-д заасан үүргээ биелүүлээгүй, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг энэ хуулийн 23.3-т заасан хугацаанаас удаа дараа хожимдуулж гаргасан бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах”

**29.2.3 “...** энэ хуулийн 29.2.2-т заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаалыг нь бууруулах”

**29.2.4 “...** энэ хуулийн 29.2.3-т заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан бол нийтийн албанаас халах” */2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан/*

**УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012.04.25-ны өдрийн 05 дугаар тогтоол**

*/2014.12.23-ны өдрийн 20, 2017.01.03-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор тус тус нэмэлт өөрчлөлт орсон./*

# ХАСУМ хянуулахгүй тохиолдол

- Сонгогддог албан тушаал
- Жирэмсэн болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаа дууссан
- Шүүхийн шийдвэрийн дагуу урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд эгүүлэн тогтоосон
- Байгууллагын бүтэц орон тоо, нэгжийн нэршилд өөрчлөлт орсон ч албан тушаалын тодорхойлолт болон эрхлэх асуудлын чиг үүрэг хэвээр

# Анхаарах асуудал

- Албан бичигт: тухайн нэр дэвшсэн албан тушаалд сул орон тоо гарсан эсвэл сонгон шалгаруулалт зарлагдах хүртэл түр орлон гүйцэтгэгчээр томилох тухай болон төрийн албаны шалгалт өгч тэнцсэн эсэх талаар тодорхой дурдсан байх, нэр дэвшигчийн овог нэрийг бүтнээр бичих,
- Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас албан бичиг ирүүлэх
- Шаардлагагүй баримт бичиг хавсаргаж ирүүлэхгүй байх /өргөдөл, ТАХ-ийн анкет, цагдаагийн тодорхойлолт, дипломын хуулбар г.м/
- Нэр дэвшигчийн ХАСУМ хянуулахаар албан бичиг ирүүлэхдээ цахим системд мэдүүлгийг бөглүүлж баталгаажуулсан байх
- Цахим системд хамаарал бүхий этгээд, нэгдмэл сонирхолтой этгээд болон боловсрол, мэргэшил, ажил эрхлэлтийн байдлыг эхнээс нь бүрэн гүйцэт үнэн зөв, бөглүүлэх
- ЭБАТ тухайн мэдүүлгийг бүрэн гүйцэт бөглөсөн эсэхийг хянаж дараа нь баталгаажуулж, илгээх
- Хүргүүлж байгаа албан бичгийн дугаарыг цахим системд зөв оруулах

# МЭДЭГДЭЛ, ТАЙЛБАР

*Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйл*

Ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөл байдал

Ашиг сонирхлын зөрчил үүссэн нөхцөл байдал

Мэдэгдэл

Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал

Тайлбар

## Ашиг сонирхлын зөрчил

“Нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг хэлнэ”

## Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал

Тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг



# Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг ямар тохиолдолд гаргах вэ?

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах, шалгаруулах, Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах, шийдвэр гаргахад оролцох

Албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй тохиолдолд

/эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцоход/

- Захиргааны шийдвэр гаргах, удирдах
- Хяналт шалгалт хийх
- Хариуцлага хүлээлгэх
- Гэрээ байгуулах



# Мэдэгдлийг яах ёстой вэ?

АЛБАН ТУШААЛТНЫ ҮҮРЭГ:

- Албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзах;
- Энэ тухай байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх, тайлбар хийх.

БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ:

- Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй гэж мэдэгдсэн мэдэгдэл, тайлбарыг хүлээн авсан удирдах албан тушаалтан шийдвэрийг бичгээр гаргана.
- Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу ЭБАТ хүлээн авах;
- Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд бүртгэх /www.meduuleg.iaac.mn/

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4-р хавсралт

**АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ, ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ**

**Нэг. Нийтийн албан тушаалтан**

| | | |
|---|---|---|
| Ургийн овог: ***Боржигон*** | Эцэг (эх)-ийн нэр: ***Лувсан*** | Нэр: ***Баяр*** |
| Албан тушаал: ***Мэргэжилтэн*** | Ажиллаж буй байгууллага: ***Соёл, спорт аялал жуулчлалын яам*** | |
| Албан тушаалд томилогдсон он, сар, өдөр: ***2012 оны 10 дугаар сарын 25-ны өдөр*** | Байгууллагын хаяг: ***УБ хот, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай, Засгийн газрын.... дугаар байр*** | |
| Албан үүргийн төрөл: ***Бараа, ажил үйлчилгээ худалдан авах, шалгаруулах*** | Тайлбар: ***ССАЖЯ-ны ТНБД-ийн 2013.05.18-ны өдрийн А/110-р тушаалаар "Архангай аймгийн .... сумын төвийн барилгын их засварын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах" үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд гишүүнээр ажилласан. Тендерын дугаар № СС-2013/05/НТШ-17*** | |

Сонирхлын зөрчилтэй эсэх   Тийм ☐   Үгүй ✔

**Хоёр. Сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал**

Нийтийн албан тушаалтан _________ ***Л. Баяр*** ____________________________________ би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэхэд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

**Гурав. Сонирхлын зөрчил үүссэн тухай**

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэх хүрээнд:

☐ Гаргах, гаргахад оролцох шийдвэр нь хамаарал бүхий этгээдтэй холбоотой гэх /хувь хүн, хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл/:

____________________________________________

☐ Гэрээ хэлцэл, хэлэлцээрийн оролцогч, эсхүл зээл, хандив, тусламж, үйлчилгээг хувь хүн, хуулийн этгээдээс авч байсан /байгаа/-тай холбогдуулж үүрэг хүлээсэн гэх:

____________________________________________

☐ Байгууллага, хуулийн этгээдэд ажиллаж байсан, гишүүнчлэлтэй, эсхүл төлөөлөл хэрэгжүүлж байсан /байгаа/ гэх:

____________________________________________

☐ Бусад /сонирхлын зөрчилтэй бусад нөхцөл байдал/:

____________________________________________

нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчил үүссэнийг мэдэгдэж, албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж байна.

**Дөрөв. Баталгаажуулалт.**

4.1. Би нийтийн албан хаагчийн үүргээ чанд ухамсарлан энэхүү мэдэгдлийг үнэн зөв гаргасан болохоо үүгээр баталгаажуулж байна.

........................................: **............................................../ Баяр /**

/албан тушаал/   /гарын үсэг/   /гарын үсгийн тайлал/

***..2013......он......06..сар.......15.өдөр***

**Шийдвэрлэсэн байдал**

Ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд албан тушаалтны албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрөх эсэх   Тийм ☐   Үгүй ☐

Хэрэв "Тийм" бол шалтгааны тэмдэглэнэ үү.

☐ Тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй

☐ Дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй

☐ Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдсан албан тушаалтан байхгүй

Баталгаажуулалт:

........................................: ........................................ /................................../

/албан тушаал/   /гарын үсэг/   /гарын үсгийн тайлал/

........он........сар........өдөр

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4-р хавсралт

## АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ, ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

### Нэг. Нийтийн албан тушаалтан

| | | |
|---|---|---|
| Ургийн овог: ***Боржигон*** | Эцэг (эх)-ийн нэр: ***Лувсан*** | Нэр: ***Баяр*** |
| Албан тушаал: ***Мэргэжилтэн*** | Ажиллаж буй байгууллага: ***Соёл, спорт аялал жуулчлалын яам*** | |
| Албан тушаалд томилогдсон он, сар, өдөр: ***2012 оны 10 дугаар сарын 25-ны өдөр*** | Байгууллагын хаяг: ***УБ хот, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай, Засгийн газрын.... дугаар байр*** | |
| Албан үүргийн төрөл: ***Бараа, ажил үйлчилгээ худалдан авах, шалгаруулах*** | Тайлбар: ***ССАЖЯ-ны ТНБД-ийн 2013.05.18-ны өдрийн А/110-р тушаалаар "Архангай аймгийн .... сумын төвийн барилгын их засварын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах" үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд гишүүнээр ажилласан. Тендерын дугаар № СС-2013/05/НТШ-17*** | |

Сонирхлын зөрчилтэй эсэх   Тийм ✓   Үгүй ☐

### Хоёр. Сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал

Нийтийн албан тушаалтан ____________________________________________ би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэхэд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

### Гурав. Сонирхлын зөрчил үүссэн тухай

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэх хүрээнд:

☐ Гаргах, гаргахад оролцох шийдвэр нь хамаарал бүхий этгээдтэй холбоотой гэх /хувь хүн, хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл/:

____________________________________________

☐ Гэрээ хэлцэл, хэлэлцээрийн оролцогч, эсхүл зээл, хандив, тусламж, үйлчилгээг хувь хүн, хуулийн этгээдээс авч байсан /байгаа/-тай холбогдуулж үүрэг хүлээсэн гэх:

____________________________________________

☐ Байгууллага, хуулийн этгээдэд ажиллаж байсан, гишүүнчлэлтэй, эсхүл төлөөлөл хэрэгжүүлж байсан /байгаа/ гэх:
***Тендерт оролцож байгаа " Алтан орд" ХХК-д 2010-2012 онд менежерээр ажиллаж байсан***

☐ Бусад /сонирхлын зөрчилтэй бусад нөхцөл байдал/:

____________________________________________

нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчил үүссэнийг мэдэгдэж, албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж байна.

### Дөрөв. Баталгаажуулалт.

Би нийтийн албан хаагчийн үүргээ чанд ухамсарлан энэхүү мэдэгдлийг үнэн зөв гаргасан болохоо үүгээр баталгаажуулж байна.

.........................................: ............................................./ ***Л.Баяр*** /
/албан тушаал/   /гарын үсэг/   /гарын үсгийн тайлал/

2013 оны 06 сарын 15 өдөр

---

**Шийдвэрлэсэн байдал**

Ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрөх эсэх   Тийм ☐   Үгүй ✓

Хэрэв "Тийм" бол шалтгааныг тэмдэглэнэ үү.

☐ Тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй

☐ Дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй

☐ Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдсан албан тушаалтан байхгүй

**Баталгаажуулалт:**

Төрийн нарийн бичгийн дарга   ..................   / ***Г.Дорж*** /
/албан тушаал/   /гарын үсэг/   /гарын үсгийн тайлал/

2013 оны 06 сарын 19 өдөр

# Дараах тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрч болно

Нэг.

Тухайн байгууллагын нэгж, эсхүл тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй

Хоёр.

Дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй;

Гурав.

Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдах ба зөвхөн ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргасан албан тушаалтан энэ шаардлагыг хангаж байгаа;

# Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт



- Өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

- Өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ашгийн төлөө үйл ажиллагаатай харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн этгээдтэй холбогдох захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

- Албан тушаалтан тухайн албан тушаалд сонгогдох, томилогдохоосоо өмнө аж ахуйн нэгжийн удирдах, гүйцэтгэх, хяналтын байгууллагын гишүүн байсан бол нийтийн албанд орсон, эсхүл тухайн аж ахуйн нэгжтэй иргэний эрх зүйн аливаа харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбогдох захиргааны шийдвэр гаргахыг хориглоно.

# Хариуцлага

- 29.2.2 ... энэ хуулийн **8.1, 8.2, 8.3**, 9.1, 19.1, 21.3, 21.4, 23.5-д заасан үүргээ биелүүлээгүй бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;
- энэ хуулийн 29.2.2-т заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаалыг нь бууруулах
- энэ хуулийн 29.2.3-т заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан бол нийтийн албанаас халах

## *АЛБАН ТУШААЛТНЫ АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛСЭН МЭДЭГДЭЛ, ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ ТАЙЛБАР ГАРГАХ АЧ ХОЛБОГДОЛ*

Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл гаргах нь Таныг албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой сонирхлын зөрчилгүй болохыг нотлон харуулах баримт болох бөгөөд ирээдүйд үүсч болох аливаа эрсдлээс хамгаалж, төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангана

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА